- Бараа материалын данс тайлант онд худалдан авч зарцуулсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, урвалж оношлуурын зарцуулагдаагүй үлдэгдлээр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжсэн "Цахим эрүүл мэнд" төслийн МN-MOH-120874-NC-RFB-PACS дугаар бүхий гэрээгээр нийлүүлэгдсэн 2,543,534.3 мянган, БНСУ-ын Экспорт Импорт банкны хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу нийлүүлсэн 6,972,274.2 мянган, нийт 9,515,808.5 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгөөр нэмэгдсэн.
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод вакцины орлого 212,202.1 мянган, эм ханган нийлүүлэх байгууллагуудаас тээврийн зардалд 241,914.8 мянган, Эрдэнэс таван толгой ХК хамтран ажиллах гэрээний дагуу 742,000.0 мянган, ёс зүйн хорооны төлбөр 7,400.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан;
- Тайлант онд Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зориулж дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудаас 47,731,390.4 мянган төгрөгийн бараа материал, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хандивласан;
- Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын тогтоолын дагуу ЗГНХ-өөс 51,378,696.8 мянган, Эрдэнэс таван толгой ХК-аас 15,500,000.0 мянган, вакцин худалдан авахад зориулж Азийн хөгжлийн банкнаас 2,917,793.4 мянган, НҮБХС-аас 29,720,314.0 мянган, ДЭМБ-аас 865,795.3 мянган, Оюу толгой ХК-аас 569,820.0 мянган, Глобал сангаас 504,166.6 мянган төгрөгийн хандив төвлөрсөн;
- Бараа, ажил үйлчилгээний зардлаас эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн худалдан авалтад 93,647,571.1 мянган, Коронавирусын 3 дугаар тунд хамруулах сурталчилгааны зардалд 1,739,080.0 мянган, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн баталгаат засварын зардалд 1,121,303.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан;
- Засгийн газрын 2021 оны 122 дугаар "Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх тухай" тогтоолоор вакцины хоёрдугаар тунг хийлгэсэн Монгол Улсын иргэн бүрд 50,000 төгрөгийн урамшуулалд олгосон 112,578,975.2 мянган, Ковид-19 цар тахлын эсрэг дайчилгаанд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад олгосон 45,603,250.0 мянган төгрөгөөр урсгал шилжүүлэг нэмэгдсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 107,383,689.5 мянган төгрөгөөр, үүнээс бараа үйлчилгээний зардалд 39,615,577.7 мянган, төрийн өмчит байгууллагад олгох татаас 62,545,779.6 мянган, урсгал шилжүүлэгт 5,222,332.2 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж дээд шатны төсөв захирагчид саналаа хүргүүлжээ.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлээр төрийн өмчит эмнэлгүүд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжиж байгаатай холбоотойгоор төрийн өмчит байгууллагад олгох татаасыг хасаж, 64,544,525.1 мянган төгрөгөөр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг баталсан байна.

Тайлант онд Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр бараа, үйлчилгээний урсгал зардлыг 119,012,882.3 мянган, урсгал шилжүүлгийг 160,160,671.2 мянган төгрөгөөр тодотгон баталжээ.

Хуулийн өөрчлөлтөөр Коронавируст халдварт /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх зорилгоор вакцины хоёрдугаар тунг хийлгэсэн иргэн бүрд олгох 50,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшууллын зардал 110,000,000.0 мянган, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 61,840,880.2 мянган, Ковид-19 цар тахлын эсрэг дайчилгаанд ажилласан

эрүүл мэндийн ажилтнуудад олгох урамшуулал 45,600,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах 1а/6836 дугаар албан бичгийн дагуу төсөвт зохицуулалт хийж ЭМЯ-ны төсвийг 4,090,442.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр 283,263,995.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 280,927,520.7 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь нийгмийн эрүүл мэнд хөтөлбөрийн зардлыг 21,755.9 мянган, эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн зардлыг 2,184,986.9 мянган, эрүүл мэндийн бодлого удирдлага хөтөлбөрийн зардлыг 129,732.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71601	Нийгмийн эрүүл мэнд	1,013,013.0	991,257.1	21,755.9	97.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	351,081.0	329,325.1	21,755.9	93.8
1.2	80809	Эмчилгээний төлбөр	304,752.0	304,752.0	-	100.0
1.3	81609	Эрүүл мэндийн үндэсний бусад хөтөлбөрүүд	357,180.0	357,180.0	-	100.0
2	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	277,004,934.9	274,819,948.0	2,184,986.9	99.2
2.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	11,200,473.9	11,185,681.6	14,792.3	99.9
2.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	1,752,678.9	1,121,303.9	631,375.0	64.0
2.3	80307	Шүүхийн шийдвэрийн дагуу олгох нөхөн төлбөр	30,130.8	30,130.8	-	100.0
2.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	49,840,194.8	49,832,339.8	7,855.0	99.9
2.5	81606	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт	85,576,028.4	84,292,126.2	1,283,902.2	98.5
2.6	81612	Вакцинжуулалт	16,605,428.1	16,596,765.7	8,662.4	99.9
2.7	81618	Вакцины урамшуулал	112,000,000.0	111,761,600.0	238,400.0	99.8
3	71603	Эрүүл мэндийн бодлого удирдлага	5,246,048.0	5,116,315.6	129,732.4	97.5
3.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,820,017.4	3,705,869.7	114,147.7	97.0
3.2	80219	Харуул, хамгаалалтын зардал	5,750.8	5,640.0	110.8	98.1
3.3	80221	Гэрээт ажиллагсдын зардал	64,192.6	60,663.4	3,529.2	94.5
3.4	80226	Байр ашиглалтын зардал	247,854.0	247,853.8	0.2	100.0
3.5	80509	Гадаадын болон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	68,226.2	68,226.0	0.2	100.0
3.6	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	521,200.0	512,623.2	8,576.8	98.4
3.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	397,843.0	395,439.5	2,403.5	99.4
3.8	81560	Монголын улаан загалмайн нийгэмлэгээр гэрээ гүйцэтгүүлэх	120,964.0	120,000.0	964.0	99.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 хөтөлбөрийн 18 арга хэмжээний хүрээнд 164 ажлыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар 80.1 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Тухайлбал:

- ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн суурь тарифыг ижил болгож амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээг төр, хувийн хэвшил ялгаагүй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн;
- ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарт ашигладаг эмнэл зүйн 7 программ хангамжийн хөгжүүлэлтийг бүрэн хийлгэж, ЭМДЕГ-тай хамтран шалгаж, бодит цагийн горимд шилжүүлсэн;
- Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн дүрс архивлан хадгалах тоног төхөөрөмж EZO дэлгэцээр тоноглогдсон workstation, программ хангамжийн хуваарилалтыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар УНТЭ, УГТЭ, ГССҮТ, Хөвсгөл, Увс аймгийн нэгдсэн эмнэлэг, Үндэсний дата төвд хуваарилан суурилуулж үйл ажиллагааг жигдрүүлсэн. Мөн E-health программ хангамжид тулгуурлан 48 эрүүл мэндийн байгууллага PACS системийг суурилуулан ашиглаж эхэлсэн;
- Засгийн газрын 2021 оны хуралдаанаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, жагсаалтад Ремдесивир тарилгын уусмал, 4 нэрийн вирусийн эсрэг эм (Тоцилизумаб, Касиривимаб, Молнупиравир, Паксловид)-ийг оруулж батлуулсан;
- ДЭМБ-ын санхүүжилттэй КОВИД-19 халдварын эсрэг дархлаажуулалтын мэдээлэл, сурталчилгааг иргэдэд сурталчлах төслийн хүрээнд нийт хүн ам болон халдварт өндөр эрсдэлтэй зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн дархлаажуулалт, халдвар хамгаалал, халдварын дараах зөвлөмж зэрэг нийт 70 гаруй нотолгоонд суурилсан мэдээлэл, сурталчилгааны зурагт хуудас, инфографик, 10 гаруй видео анимешн бичлэгийг монгол, казак, дохионы хэл дээр боловсруулан олон нийтийн цахим сүлжээ, хэвлэмэл, электрон хэлбэрээр түгээсэн.
- Ковид-19 халдвар, бага насны хүүхдийн халдвар хамгаалал сэдвийн хүрээнд орон нутгийн нийт 600 гаруй эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан болон 119 төвийн операторуудад цахим сургалт зохион байгуулсан;
- Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Олон улсын хөл хориотой халдварт өвчний голомтод болон гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтанд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийг 92 байгууллагын 39072 эмч, эмнэлгийн ажилтанд олгосон зэрэг асуудлыг онцолж байна.

Засгийн газрын 2020 оны “Ой тэмдэглэх тухай” 250 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсад Эрүүл мэндийн алба, орчин цагийн анагаах ухаан үүсэж хөгжсөний 100 жилийн түүхэн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд зориулан төсвөөс 286,413.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн худалдан авалтад 93,647,571.1 мянган, Коронавирусын эсрэг вакцин худалдан авахад НҮБХС болон АХБ-ны санхүүжилтээр 48,048,015.1 мянган төгрөг зарцуулсан;

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа улсын эмнэлэг, үндэсний төвүүдэд ашиглагдаж байгаа өндөр өртөгт тоног төхөөрөмжийн урсгал засварын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг яам дээр зохион байгуулж 1,121,303.9 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагуудад олгосон;

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас өндөр насны тэтгэвэрт гарч байгаа 220 гаруй албан хаагчид тэтгэвэрт гарахад нэг удаа олгох мөнгөн тэтгэмжийн зардалд 4,581,932.4 мянган төгрөг зарцуулсан;

Засгийн газрын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллын хүрээнд үйл ажиллагаа явуулах, байгууллагын хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлээр тавих дотоод хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант онд 173 мэдээллийг ил тод байршуулахаас 1 мэдээллийг байршуулаагүй, 547,443,799.5 мянган төгрөгийн 70 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах, албан шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Ковид, Папиломо вирус, томуугийн нэвтрүүлэг, Ковид-19 цар тахлын 3 дугаар тунд хамруулах сурталчилгаанд зориулж 1,739,080.0 мянган төгрөгийг ТБОНӨХБАҮХАТ-ийн дагуу нээлттэй тендер зарлалгүй, шууд худалдан авалтын босго үнэд багтаан 191 хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулсан, Пролианс ХХК-аас 1,573,200.0 мянган, Шинэ Сэгэ Мед ХХК-аас 207,000.0 мянган төгрөгийн урвалж оношлуур худалдан авах гэрээ байгуулахаас өмнө барааг хүлээн авч данс бүртгэлд тусган, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээ байгуулахдаа холбогдох хууль журмын заалтуудыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

2. Тайлант онд нийт 4,872,748,500.00 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурыг байгууллагуудад тараах хуваарийг нийлүүлэгчдэд баталж өгөөгүй, гэрээ дүгнэсэн актыг тухай бүр үйлдээгүй, гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал үүссэн тухай албан бичгээр заавар өгөөгүй, гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг тодорхойлоогүй зэрэг захиалагчаас шалтгаалан гэрээнд заасан хугацаанаас 1-65 хоног хоцроосон байна.

Энэ нь Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1 Захиалагч дараах үүрэг хүлээнэ, 351.1.2 “гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.4 “Захиалагч тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар зөвхөн албан бичгээр харилцана” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгчид бичгээр заавар өгөөгүй, хуваарийг баталж мөрдүүлээгүй, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг тодорхой тусгаагүй, гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад анхаарах, үр ашгийг нэмэгдүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах талаар өгсөн 5 албан шаардлагын биелэлт 60.0 хувь, 19,404,454.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 78.6 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	1,673,451.6	3	1,669,712.0	2	3,739.6	60.0
Зөвлөмж	5	19,404,454.0	3	4,147,732.8	2	15,256,721.2	78.6
Нийт дүн	10	21,077,905.6	6	5,817,444.8	4	15,260,460.8	69.3

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Коронавирусын эсрэг вакцинжуулалтын хоёрдугаар тунг хийлгэсэн иргэдэд олгосон урамшууллын 112,578,975.2 мянган төгрөгийг иргэдийн И-баримтад бүртгэлтэй дансанд хуваарилах ажлыг Сангийн яам зохион байгуулсан тул гүйцэтгэлийг харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар, Монгол Улсад Эрүүл мэндийн алба, орчин цагийн анагаах ухаан үүсэж хөгжсөний 100 жилийн түүхэн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив тусламж, түүний зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 117,050,226.9 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс, 30,555,118.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 30,254.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 86,412,488.8 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 52,365.7 мянган төгрөгийн зөрчлийн давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 87,148,560.6 мянган төгрөгийн зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан тул Сөрөг санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд 15,403,066.2 мянган төгрөгийн орлогыг дутуу тусгасан;
- ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын дансанд бүртгэсэн Унгар улсын Засгийн газрын хандиваар нийлүүлэгдсэн 5,588,081.5 мянган төгрөгийн үнэтэй 33 иж бүрдэл амьсгалын аппаратыг давхардуулан бүртгэсэн;
- Үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материал данснаас 48,162.2 мянган төгрөгийн Ремдисивир эмийг тушаалын дүнгээс зөрүүтэй хуваарилсан;
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжсэн Цахим эрүүл мэнд төслийн MN-МОН-120874-NC-RFB-PACS дугаар бүхий гэрээгээр нийлүүлэгдсэн 2,543,534.3 мянган төгрөгийг хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Экспорт Импорт банк хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу нийлүүлсэн 6,972,274.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусган залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 181/ШШ2021/00045, 181/ШШ2021/01699 дугаар захирамжаар ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 30,254.0 мянган төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” 67/А/268, А/387/99 дугаар хамтарсан тушаалаар ЭМДС-аас тайлант онд 368,618,174.7 мянган төгрөгийн Ковид-19-ын эмчилгээний төлбөрийг төр, хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байхад Эрүүл мэндийн яам давхардуулан 93,647,571.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн худалдан авалтыг ЭМЯ хийж, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах”, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны 67/А/268 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” журмын 3.7 “энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон

холбогдох бусад шууд бус зардал багтана” гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Яамны нийтлэг эрхлэх асуудал үндсэн чиг үүрэгт тусгагдаагүй ажлыг гүйцэтгэхгүй байх, эмчилгээний эм бэлдмэл, хэрэгслэлийг давхардуулан олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

3. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглахад зориулж 4 /Арбидол, Умифеновир, Тоцилизумаб, Ремдесивир/ төрлийн эм худалдаж авахад нийт 26,151,544.2 мянган төгрөг зарцуулсан. Тайлант онд 13,190,388.2 мянган төгрөгийн эмийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар төр, хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн газруудад хуваарилж 12,961,156.0 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байна. Эмийн үлдэгдлийн 55 хувийг 7,103,625.0 мянган төгрөгийн Тоцилизумаб /400мг/20мл/, 41 хувийг 5,263,932.7 мянган төгрөгийн Ремдесивир /100мг/ эм эзэлж байна.

Энэ нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 “Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглах нөөцөд байх эмийн жагсаалтыг батлах, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг боловсруулж хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага өгөх.

4. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын бусад байгууллагуудад хуваарилсан 62,888,763.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор иргэдийг дархлаажуулалтын 3 дугаар тунд хамрагдахыг уриалах, дархлаа сэргээх нэмэлт тунгийн ач холбогдол, түүнд хэрхэн хамрагдах талаар заавар, мэдээ, мэдээллийг бэлтгэн сурталчлах, олон нийтэд хүргэх арга хэмжээнд зориулан хэвлэл, мэдээллийн байгууллагуудад урьдчилж олгосон 1,553,080.0 мянган төгрөг, нийт 64,441,843.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлсэн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урьдчилж олгосон зардлыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн салбарын болон бусад байгууллага, аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө, бараа материал, урьдчилж гарсан зардал, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж тооцоог бодож байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага өгөх.

5. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлын данснаас Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181/ШШ2020/01216 дугаартай захирамжаар нэхэмжлэгч Баярс Констракшн ХХК-ийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 23,208.0 мянган төгрөгийг хариуцагч Эрүүл мэндийн яам төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүү, төсвийг зохистой удирдаж, төсвийн төслийг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, төсвийг үр ашиггүй зарцуулахгүй байх, Албан шаардлага өгөх

6. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмж, өмнөх оны аудитаар өгсөн “Хан-уул дүүргийн 300 ортой амаржих газрын барилгын ажлыг гүйцэтгэж

байсан аж ахуйн нэгжийн 4,141,626.4 мянган төгрөгийн нэхэмжлэлийн дагуу тус яамны эд хөрөнгийг Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 181/ШЗ2018/04116 дугаартай захирамжаар битүүмжилснийг шийдвэрлүүлэх" талаарх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулаагүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, Албан шаардлага өгөх.

7. Мөнхийн тун ХХК-аас 2020 онд байгуулсан 416 дугаар "Нэг удаагийн амны хаалт", 412 дугаар "Үзлэгийн бээлий", 408 дугаар "Нэг удаагийн халад", 406 дугаар "Нэг удаагийн улавч" худалдан авах гэрээнүүдийн нийт үнийн дүнгийн 20 хувьд 2021 онд 89, 91, 92, 93 дугаар "Нэг удаагийн комбинзон" нийлүүлэх нэмэлт гэрээг шууд байгуулан 4,303,180.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Саммит медиал ХХК-тай "Өндөр өртөгтэй тоног төхөөрөмж Phillips: Соронзон резонанст томографын аппарат засвар"-ын 340,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 433 дугаартай гэрээ байгуулсан боловч 499,262.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 "нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол", 41 дүгээр зүйлийн 41.1 "худалдан авах гэрээнд дараах өөрчлөлт хийхийг хориглоно", 41.1.2 "энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаа, засвар үйлчилгээний хэрэгцээ, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа тооцоог хийсний үндсэн дээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, албан шаардлага өгөх.

8. Тайлант онд нэмэлт төсвийн дансаар санхүүжүүлж байгаа Глобал сангийн ДОХ/Сүрьеэгийн төслийн хөрөнгөөр 77,200.0 мянган төгрөгийн үнэтэй эхоны аппарат, хүн амын дунд мэдээлэл сурталчилгаа хийх 45,760.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт, Глобал сангийн үндэсний зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр худалдан авсан 21,484.6 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, оффисын тавилга, эм, эмнэлгийн хэрэгслийг данс бүртгэлд тусгаагүй, Орбис төслийн санхүүжилтээс Силвер дизконс ХХК-аар хэвлэлийн ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний нэмэлтийг үндсэн гэрээний 20 хувиас хэтрүүлэн 8,535.0 мянган төгрөгөөр байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3 "Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно", 34 дүгээр зүйлийн 34.1.3 "нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн дансаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ТӨБЗГ-ын 2021 оны 361 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 31,960.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Тоёота Ландкрузер-200 маркийн автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан. Тайлант онд уг автомашины урсгал засварт 28,195.6 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өмчид байгаа данс бүртгэлтэй автомашиныг ашиглаж, нэмэлт засвар үйлчилгээний зардал шаардагдах хэрэгцээ шаардлага хангахгүй автомашиныг балансаас балансад шилжүүлэн авахгүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд бичиг хэргийн материалын 23,101.2 мянган төгрөгийн худалдан авалт, шуудан холбоо интернэтийн төлбөрт төлсөн 1,068.9 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтууд, Үнэлгээ ба хуваарилалт, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж, шууд зардлаар бүртгэхгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Эрүүл мэндийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгуул-лагын нэр	Ауди-тын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуц лага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг дутуу тусгасан	Аудитын явцад залруулсан.	1	15,403,066.2	1	15,403,066.2						
2	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Унгар улсын Засгийн газрын хандиваар нийлүүлэгдсэн 33 иж бүрдэл амьсгалын аппаратыг давхардуулан бүртгэсэн	Аудитын явцад залруулсан.	1	5,588,081.5	1	5,588,081.5						
3	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материал данснаас Ремдисивир эмийг тушаалын дүнгээс зөрүүтэй хуваарилсан	Аудитын явцад залруулсан.	1	48,162.2	1	48,162.2						
4	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.	Аудитын явцад залруулсан.	1	9,515,808.5	1	9,515,808.5						
5	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг байгууллагаас олгосон байна.	Уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх.	1	30,254.0			1	30,254.0				
6	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	ЭМДС-аас тайлант онд 368,618,174.7 мянган төгрөгийн Ковид-19-ын эмчилгээний төлбөрийг төр, хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байхад 93,647,571.1	Эмчилгээний эм бэлдмэл, хэрэгслэлийг давхардуулан олгохгүй байх	1	-					1	-		

АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ

Эрүүл мэндийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, нэг удаагийн хамгаалах хэрэгслийн худалдан авалтыг ЭМЯ хийж, эрүүл мэндийн байгууллагуудад давхардуулан хуваарилсан байна.												
7	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглахад зориулж 4 төрлийн эм бэлдмэл худалдаж авахад нийт 26,151,544.2 мянган төгрөг зарцуулсан. Тайлант онд 13,190,388.2 мянган төгрөгийн эмийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар төр, хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн газруудад хуваарилж 12,961,156.0 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байна.	Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглах нөөцөд байх эмийн жагсаалтыг батлах, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг боловсруулж хэрэгжүүлж ажиллах	1	13,190,388.2					1	13,190,388.2			
8	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 64,441,843.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлсэн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урьдчилж олгосон зардлыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Эрүүл мэндийн салбарын болон бусад байгууллага, аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө, бараа материал, урьдчилж гарсан зардал, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж тооцоог бодож байх	1	64,441,843.8					1	64,441,843.8			
9	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлын данснаас Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181/ШШ2020/01216 дугаартай захирамжаар	Санхүү, төсвийг зохистой удирдаж, төсвийн төслийг үндэслэлтэй, бодитой төлөвлөж, төсвийг үр ашиггүй зарцуулахгүй байх	1	23,208.0					1	23,208.0			

Эрүүл мэндийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			улсын тэмдэгтийн хураамж төлсөн байна.																
10	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт, шалгалтын зөвлөмж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулаагүй.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж ажиллах,	1	4,141,626.4						1	4,141,626.4						
11	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Анх нийлүүлсэн барааг өөрчлөн нэмэлт гэрээгээр 4,303,180.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Өндөр өртөгтэй тоног төхөөрмжийн засварын гэрээний дүнгээс 159,262.8 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон.	Худалдан авах ажиллагаа, засвар үйлчилгээний хэрэгцээ, шаардлагатай тоног төхөөрмжийн судалгаа тооцоог хийсний үндсэн дээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах	1	4,462,442.8						1	4,462,442.8						
12	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	Тайлант онд нэмэлт төсвийн дансаар санхүүжүүлж байгаа төслийн хөрөнгөөр худалдан авасан хөрөнгө, тоног төхөөрмжийг данс бүртгэлд тусгаагүй, шууд худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	Нэмэлт төсвийн дансаар санхүүжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах	1	152,979.6						1	152,979.6						
13	ЭМЯ	АХГ-2022/381/НА-СТА-ТШЗ	ТӨБЗГ-ын 2021 оны 361 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан 31,960.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Тоёота Ландкрузер-200 маркийн автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан. Тайлант онд уг автомашины урсгал засварт 28,195.6 мянган төгрөгийг зарцуулсан.	Байгууллагын өмчид байгаа данс бүртгэлтэй автомашиныг ашиглаж, нэмэлт засвар үйлчилгээний зардал шаардагдах хэрэгцээ шаардлага хангахгүй автомашиныг балансаас балансад шилжүүлэн авахгүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулахгүй байх	1	28,195.6											1	28,195.6	
